



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

161 /161/

2021.10.21

ҮЙЛ ЯВДАЛ

ШИНЭ СУРГУУЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТ БОЛЛОО

Зэвсэгт хүчний 2021-2022 оны сургуулийн жилийн нээлт өчигдөр боллоо.

Шинэ сургуулийн жилийн нээлтийн хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг цахим уулзалтыг хийж ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагч, удирдлага, бие бүрэлдэхүүнд хандаж үг хэллээ.

Тэрээр "Бид бүхэн 2020-2021 оны сургуулийн жилд цэргийн сургалт бэлтгэлээр дэвшүүлсэн зорилго, зорилтоо бүрэн хангаж, шинэ сургуулийн жилийн зорилго, зорилт, түүнийг хангахад чиглэсэн үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байна. Өнгөрсөн сургуулийн жилд бид Батлан хамгаалах яамны 110, Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэх, түүхтэй ойгоо цэргийн сургалт бэлтгэлийн өндөр амжилтаар утгахад чиглэсэн томоохон зорилго, зорилт, үйл ажиллагааг төлөвлөж, амжилттай хэрэгжүүлснээрээ онцлог байлаа. Түүнчлэн Зэвсэгт хүчний шинэчлэлийн бодлогын хүрээнд Төрлийн цэргийн командлалуудыг шинээр байгуулсан нь онцлог үйл явдал мөн. Төрлийн цэргийн командлалууд шинээр байгуулагдсан нь Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн бодлого, чиглэлийг тодорхойлох, түүний тогтолцоог шинэчлэх, төрлийн цэргийн сургалт бэлтгэлийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, төрөл, тусгай мэргэжлийн цэргийн бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэх чиг үүрэгт нь нийцсэн цэргийн сургалт бэлтгэлийн агуулга, зохион байгуулалтыг шинэчлэх зайлшгүй хэрэгцээг бий болгосон юм. Энэ ч үүднээс шинэ сургуулийн жилийн өмнөхөн бид "Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн бодлого" баримт бичгийг боловсруулж, түүндотроо цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн тодорхойлоод байна. Цаашлаад энэхүү бодлогын баримт бичигт нийцүүлэн "Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий журам", Төрлийн цэргийн командлалуудын түвшинд "Цэргийн сургалт бэлтгэлийн заавар" болон удирдлага, зохион байгуулалтын бусад баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлснээр Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн бодлогын хүрээнд төрөл, тусгай мэргэжлийн цэргийн сургалтын агуулга, зохион байгуулалт шинэчлэгдэж Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт



хүчнийг хөгжүүлэх, бэхжүүлэх үндсэн зорилгодоо хүрэх болно" гэв. Мөн өнгөрсөн сургуулийн жилд дэлхий нийтийг хамарсан цар тахлын гамшгийн үед цэргийн сургалт бэлтгэлийг тасалдалгүй, үр дүнтэй зохион байгуулахад бүхий л хүч чадлаа дайчлан ажилласан гэдгийг дэслэгч генерал Д.Ганзориг онцлолоо. Тэрээр дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр өвчин зовлон, хөл хорио, санхүү, эдийн засгийн болон сэтгэл зүйн олон хүндрэл бэрхшээл тулгарсан ч нийт бие бүрэлдэхүүнийхээ хичээл, итгэл,

зүтгэлээр энэ бүхнийг амжилттай даван туулж, дэвшүүлсэн зорилго, зорилтуудаа хангаж чадлаа гэдгийг дүгнэн хэлсэн юм. Үргэлжлүүлэн "Аливаа хүндрэл бэрхшээлээс ч ашигтай, давуу талыг олж болдгийн жишээгээр өнгөрсөн хугацаанд бид бүхэн цар тахлын нөхцөл байдлаас үүдэн цэргийн сургалт бэлтгэлд цахим сургалтын арга, техник, технологийг нэвтрүүлэхийн зэрэгцээ цэргийн алба хаагчид бие даан өөрийгөө хөгжүүлэх асар их боломж, хэрэгцээ, шаардлага байгааг олж харлаа. Мөн Батлан хамгаалахын сайдын тушаалаар "Зэвсэгт

хүчний офицер, ахлагч нарын түвшин тогтоох үзлэг"-ийг зохион байгуулж байгаа нь бие бүрэлдэхүүнийхээ албандаа хандах хандлага, бие бялдар, сэтгэл зүй, мэргэжлийн ур чадварыг бодитоор үнэлж, дүгнэхэд чиглэсэн томоохон ажил, арга хэмжээ болж байна. Ингэснээр цаашид мэргэжлийн цэрэгт суурилсан сургалтыг төрөл, мэргэжлийн цэргийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны онцлогтой уялдуулан шинэчлэх эхлэл тавигдаж байгаа" гэдгийг тодотголоо.

Ийнхүү ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд хандаж үг хэлсний дараа ЗХЖШ-ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал Ц.Гандорж цаг үеийн тулгамдсан асуудлуудаар мэдээлэл хийсэн юм. Мөн ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын

газрын даргын орлогч, хэлтсийн дарга, хурандаа Д.Дугаррагчаа "Зэвсэгт хүчний 2021-2022 оны сургуулийн жилд дагаж мөрдөх цэргийн албаны талаарх баримт бичгүүдийн агуулга, хэрэгжилтийг тоцоох" сэдвээр, Сургалтын бодлого зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа Э.Мөнх-Оргил "Зэвсэгт хүчний 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах онцлог" сэдвээр сургалт явуулж, харилцан ярилцлага өрнүүлэн нэгдсэн ойлголтод хүрсэн юм.

Түүхэнд энэ өдөр

1980 он:

"Залуучуудын цэргийн бэлтгэлийг дээшлүүлэх арга хэмжээний тухай" МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн хамтарсан тогтоол гарчээ.

1993 он.

"Монгол Улсын хилийн тухай хууль" батлагдв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 7	🌧️ -9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	🌧️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,848.00	2,844.00
EUR 🇪🇺	3,311.08	3,288.00
CNY 🇨🇳	445.53	444.50
RUB 🇷🇺	40.10	39.60
JPY 🇯🇵	24.91	24.67
KRW 🇰🇷	2.42	2.38

ЗУРХАЙ

2021.10.21 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 16/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН ХОЁР ХАР ХАР БАР ӨДӨР

Үс засуулбал:
Өлзийтэй сайн
Өвчин ирнэ:
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.20-17.53
Барилдлага:
Хотол чуулган
Шүтэн барилдлага:
Сансар
Суудал:
Мод

Тухайн өдөр морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнес эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, хараал, жатхыг буцаах, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, гэр, байшингийн суурь тавихад сайн. Золиг гаргах, бомбын үйл, бэрийн үйлд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЦЭРЭГ ТАТЛАГА НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ӨНӨӨДӨР ЭХЭЛЖ БАЙНА

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын А/721 тоот захирамжийн дагуу нийслэлийн есөн дүүрэгт энэ өдөр цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэг эхэлж байна. Цар тахалтай холбоотойгоор цэрэг татлагын байрыг тусгайлан бэлтгэж УОК-оос гаргасан халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажиллаж байгаа юм.

Энэ удаагийн цэрэг татлагаар Улаанбаатар цэргийн хүрээний ангиудад хуваарилагдсан залуусыг төв дамжинд цуглуулахгүй шууд ангид нь хүргэхээр зохицуулалт хийх аж. Хугацаат цэргийн албанд татагдагчид нь иргэний үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэх, мэргэжил эзэмшсэн бол мэргэжлийн үнэмлэх, их, дээд сургууль төгссөн бол диплом зэрэг баримт бичгээ биедээ авч, цэрэг татлагын байранд тогтоосон хугацаанд ирэх үүрэгтэй.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
334.696 +1744

ЭДГЭРСЭН
453,036 +6064

НАС БАРСАН
1519 +16

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
5745 +98

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
198

ЭДГЭРСЭН
5436

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 242,324,272

Эдгэрсэн

Нийт: 219,670,460

Нас барсан

Нийт: 4,928,811

Цахим шууданд

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМТЭД ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД ОРОЛЦЛОО

Олон улсын цэргийн шинжлэх ухааны нийгэмлэг (The International Society of Military Sciences)-ээс "Progress in Military Sciences for Resilience and Cohesion in the Face of New Forms of Disruption" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2021 оны 10 дугаар сарын 11-14-нд Канадын Онтарио хотод зохион байгууллаа. Тус хуралд Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид оролцсон бөгөөд Австрийн Үндэсний батлан хамгаалах академи, Балтийн Батлан хамгаалахын коллеж, Данийн Батлан хамгаалахын коллеж, Канадын Хатан хааны

судалгааны ажлын үр дүнг хэлэлцлээ. Монгол Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургууль Олон улсын цэргийн шинжлэх ухааны нийгэмлэгт энэ онд элсэж, олон улсын батлан хамгаалах салбар, цэргийн шинжлэх ухааны судлаач нартай эрдэм шинжилгээ судалгааны үр дүнгээ хуваалцаж, шинжлэх ухааны эргэлтэд оруулах боломж нээгдэж байна.

Олон улсын эрдэм шинжилгээний хуралд Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдаас Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Эрдэм шинжилгээ



цэргийн коллеж, Финляндын Үндэсний батлан хамгаалахын академи, Нидерландын Үндэсний батлан хамгаалахын академи, Норвегийн Батлан хамгаалахын их сургууль, Португалын Цэргийн хүрээлэн, Шведийн Батлан хамгаалахын их сургууль зэрэг 20 гаруй орны батлан хамгаалахын их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 90 гаруй эрдэмтэн судлаачид 10 салбар хуралдаанд оролцож, сүүлийн үед явуулсан өөрсдийн

түншлэл хариуцсан дэд захирал, доктор (Sc.D), профессор, хурандаа Б.Өлзийхуяг, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), профессор, хурандаа Т.Соронзонболд, Стратеги судалгааны хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), хурандаа Ж.Мэндээ, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Аюулгүй байдал батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор Х.Орхончимэг нар оролцлоо. Тус хуралд

оролцогчид "The issue of development of a new defense education system in Mongolia" сэдэвт илтгэлийг амжилттай хэлэлцүүлсэн юм.

Цаашид цэргийн урлаг, шинжлэх ухааны чиглэлийн судалгаа, академик боловсролын асуудлуудаар олон орны батлан хамгаалах салбарын эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллах, судалгааны ажлаа өргөжүүлэх бүрэн боломжтой.

“АВТО БУУХИА” НОРМАТИВЫН ТЭМЦЭЭНИЙГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Зэвсэгт хүчний 065 дугаар анги

Харьяа байгууламж, тусгай ротын удирдах бүрэлдэхүүний “Заах арга зүйн цуглалт”-ийг 2021 оны 10 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд ангийн байрлалд зохион байгуулж явууллаа.

Цуглалтаар ангийн захирагчийн баталсан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу сургуулийн гурван бүлэгт хуваарилагдсан багш нар байгууламжийн дарга, тусгай ротын захирагч, холбооны салааны захирагч болон жолооч зэрэг албан тушаалтнуудад сургалт явуулсан юм. Мөн соёл хүмүүжлийн ажлын хүрээнд “Авто буухиа” нормативын тэмцээнийг 2021 оны 10 дугаар сарын 16-ны өдөр ангийн байрлалд тавиулангийн талбайд зохион байгуулав. Тэмцээнд Хорооны төвөөс хоёр байгууламж, тусгай ротын 11 нийт 13 цэргийн алба хаагч олон, болон дадлагаар өрсөлдлөө.

Тэмцээний өмнө жолооч нарын онолын мэдлэгийг шалгаж урьдчилан бэлтгэсэн тестээр шалгалт авсан юм. Дадлагаар 8 ширхэг тугийг ухарч сүлжих автомашинтай 3-ын холбоо хийж зэвсгийн 13, 14 дүгээр норматив болон автомашинтай ирж 90 градуст ухрах гэсэн шалгууран зохион байгуулснаас тэргүүн байрт 281 дүгээр байгууламжийн жолооч, ахлах ахлагч Г.Батсүх, дэд байрт хорооны төвийн авто тээврийн салааны жолооч, ахлах ахлагч П.Цэдэнсодном, тусгай байрт 329 дүгээр тусгай ротын жолооч, ахлагч Б.Даваа нар шалгаран бусдыгаа хошуучиллаа. Тэмцээний шагналыг 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Агаарын цэргийн командлагч,



хошууч генерал О.Энхбаяр ангийн байрлалд гардуулж өглөө.

Мөн энэ үеэр ЗХЖШ-ын даргын 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн тушаалаар батлагдсан Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын таних тугийн нэгдсэн зааврыг шинэчлэн баталсантай холбогдуулж ангийн харьяа байгууламж, тусгай ротуудын “Таних туг”-ийг зааврын дагуу хийж

гүйцэтгэн байгууламжийн дарга, салбарын захирагч нарт гадуулан өгөв.

Ангийн таних тугийг гадаадын зочид төлөөлөгчтэй хийх уулзалт, ёслол хүндэтгэлийн арга хэмжээ, төрөл бүрийн биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, соёл урлагийн арга хэмжээний нээлт, хаалтад зориулан хэрэглэх юм.

Ахмад З.АНХБАЯР

ТУСГАЙ САЛБАР ТҮҮХТ 50 ЖИЛИЙН ОЙГОО ТЭМДЭГЛЭЛЭЭ



Зэвсэгт хүчний 124 дүгээр анги

Тусгай салбарын 50 жилийн ойн хүрээнд олон төрлийн ажил, арга хэмжээг зохион байгуулж явуулсны нэг нь Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн тусгай салбар анх удаа зохион байгуулсан заах арга зүйн цуглалт байв. Цуглалтаар 143, 148, 168 дугаар тусгай салбаруудын цэргийн сургалт бэлтгэлд үнэлэлт дүгнэлт өгч харилцан ажиллагааг дээшлүүлэх, дадлага туршлага

шинээр цэцэрлэгт хүрээлэн байгуулан хайлаас, шар хуайс, улиас, чацаргана, алим, чавганы модыг суулгаж нийт 1148 мод тарьж цэцэрлэгт хүрээлэнгийнхээ нэрийг “Тэрбум мод” гэж нэрлэн нээлтийн арга хэмжээг эхлүүлэв.

Эл арга хэмжээнд ангийн удирдлага, цэргийн хүрээний байгууллагын төлөөлөл, орон нутгийн удирдлагууд оролцсон юм.

Мөн Зэвсэгт хүчний 148 дугаар тусгай салбарын 50 жилийн ойд зориулсан Цэргийн ёслолын жагсаал

Засаг дарга Р.Сэддорж, Цэргийн штабын дарга, дэд хурандаа Д.Эрдэнэбаяр, Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн захирагч, хурандаа Ж.Амаржаргал болон аймаг орон нутгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлага, төлөөлөл оролцлоо. Энэ үеэр албандаа идэвх, зүтгэл, үр бүтээлтэй ажилласан алба хаагчдыг ЗХЖШ-ын Жуух бичиг, Тагнуулын газрын шагнал, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”, Даланзадгад сумын ИТХ-ын даргын өргөмжлөл, Өмнөговь Цэргийн хүрээний байгууллагуудын шагналуудаар шагнаж урамшууллаа.

Түүнчлэн тус тусгай салбар түүхт 50 жилийн ойгоо угтан сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх зорилгоор хичээлийн хоёр танхимыг засварлан тохижуулж, жагсаалын талбайг өргөтгөн засварлаж, ШНБ-ны шороон зам дагуу шинээр 65 метр авто замыг тус тус бетондож цутган, салбарын байрны гадна талын өнгө үзэмжийг сайжруулсан зэрэг олон ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн тусгай салбарынхаа түүхт дайчин уламжлагыг илэрхийлсэн зурагт сэтгүүл, баримтат киног хийсэн юм.

Ахлах дэслэгч Д.ЭНХНАСАН



хуваалцах, шинэ сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөг боловсруулсан юм. Мөн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж цэргийн хотхоны талбайд

явуулж, тусгай салбарын ахмад дайчид Байлдааны туганд хүндэтгэл үзүүллээ.

Баярын хурлаар ангийн захирагч, хурандаа Ч.Алтангэрэл, аймгийн

“ОРОС ҮНДЭСТНИЙ ӨДӨРЛӨГ”-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Зэвсэгт хүчний 284 дүгээр анги

Бүрэлдэхүүний зохистой хоололтын талаарх ойлголтыг дээшлүүлэх зорилгоор өчигдөр “Орос үндэстний өдөрлөг”-ийг зохион байгууллаа. Эл өдөрлөгийн хүрээнд I хоол, долоон төрлийн II хоол, гурван төрлийн зууш, хоёр төрлийн талх, нарийн боов, хоёр төрлийн ундаа, цай гэх мэт олон төрлийн амтат хоол, зуушаар бие бүрэлдэхүүнд үйлчиллээ.

